



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ**

2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
төслийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 62 дугаар зүйлийн 62.1.1, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийг зохих журмын дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (М.Алтан-Очир)-т даалгасугай.
3. Нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ДҮРЭМ

(Шинэчилсэн найруулга)

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн оноосон нэр нь монголоор “Монголын Цахилгаан Холбоо” Хувьцаат Компани /цаашид “Компани” гэх/, англиар “Mongolia Telecom Joint Stock Company”, товчилсон нэр нь монголоор “МЦХ ХК”, англиар “МТС” байна.
- 1.2. Компанийн оршин байгаа газар: Монгол Улс, 15160 Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг I хороо, Энхтайваны өргөн чөлөө 1, Шуудангийн хайрцаг 1166 болно.
- 1.3. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмээр зохицуулна.
- 1.4. Компани нь энэхүү дүрмийн 1.3-т дурдсан хуулиудын дагуу нээлттэй хувьцаат компани юм.
- 1.5. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах, хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд “ХК” гэсэн тэмдэглэгээг заавал хэрэглэнэ.
- 1.6. Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн шийдвэрээр, охин компанийг Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/-ын шийдвэрээр байгуулна. Салбар нь компанийн төв оффисийн оршин байгаа газраас өөр газар байрлан, компанийн нэрийн өмнөөс түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг гүйцэтгэх тусгай нэгж бөгөөд хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.
- 1.7. Компани нь ТУЗ-өөс баталсан өөрийн лого болон барааны тэмдэгтэй байна. Уг лого болон барааны тэмдгийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн Компани эдэлнэ.
- 1.8. Компани нь өөрийн нэр, лого болон барааны тэмдэг бүхий албан бичгийн хуудас тэмдэгтэй байна.
- 1.9. Энэ дүрэмд дурдсан хууль тогтоомж, журмыг тухайн үед орсон нэмэлт өөрчлөлт болон шинэчилсэн байдлаар мөрдөнө.
- 1.10. Компани нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл

- 2.1. Компани нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, нийгэм эдийн засгийн үүрэг хариуцлагыг дараах байдлаар хүлээнэ.

- Иргэд, бизнес, засгийн газрын болон бусад хэрэглэгчдэд өндөр чанартай, харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх.
- Ашиг, орлогоо нэмэгдүүлэхийн тулд технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн ажиллах хувьцаа эзэмшигчиддээ үр өгөөжтэй байх.

2.2. Компани нь харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээ болон хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлнэ.

2.3. Компанийн дүрмийн 2.2-т заасан үйл ажиллагааг явуулахад шаардагдах тусгай зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авна.

Гурав. Компанийн хувьцаа

3.1. Компанийн зарласан энгийн хувьцаа 25,870,275.89 ширхэг бөгөөд хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнэ 100 төгрөг байна.

3.2. Компаниас шинээр нэмж гаргах хувьцааны тоог ХЭХ-аар шийдвэрлэнэ. Зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах тоо, хугацаа болон бусад нөхцлийг ТУЗ тогтооно. Хувьцаа нь энгийн ба давуу эрхтэй байж болно.

3.3. Хувьцаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

3.4. Компани өөрийн хувьцааг худалдан авах буюу дахин зарж болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны 25 хувиас илүүг худалдан авч болохгүй.

3.5. Компани энэ дүрмийн 4.4, 4.5-д зааснаас бусад тохиолдолд өөрийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авах асуудлыг ХЭХ-аар шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Хувьцаа эзэмшигч

4.1. Компанийн энгийн хувьцааг эзэмшсэн Монгол Улсын болон гадаадын хуулийн этгээд, хувь хүн компанийн хувьцаа эзэмшигч байна.

4.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь дараах үндсэн эрхийг эдэлнэ:

4.2.1. ХЭХ-д оролцож өөрийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны хувь тэнцүүлэн санал өгөх;

4.2.2. ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу эзэмшиж байгаа хувьцаанд оногдох ногдол ашиг авах;

4.2.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 зүйлд заасны дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;

4.2.4. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар компаниас нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдаж авах.

4.3. Хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй.

4.4. ХЭХ-аас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцаагаа Компанийн тухай хуульд заасны дагуу эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй:

4.4.1. Нийлүүлэх, нэтгэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулсан;

4.4.2. Компанийн нийт хөрөнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон их хэмжээний хэлцэл хийгдсэн;

4.4.3. Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлт орсон.

4.5. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн авахыг Компаниас шаардах эрхтэй.

4.6. Санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор Компанийн энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ХЭХ-д хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал оруулах эрхтэй. Дээрх эрхийг нь хэрэгжүүлэхийн тулд Компани хурал хуралдахаас хоёр сарын өмнө бичгээр тэдэнд мэдэгдэл хүргүүлнэ.

4.7. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 3 хоногийн дотор компанийн ТУЗ-д бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн ХЭХ-д асуудал хэлэлцүүлэхээр оруулах хуульд заасан эрхээ эдлэх баталгаа болно.

4.8. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 болон 98 дугаар зүйл, энэ дүрмийн 7.27-д заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.

4.9. Компанийн энгийн хувьцааны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн аливаа албан тушаалтныг компанид болон өөрт нь хохирол учруулсан гэж үзвэл Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйл болон холбогдох заалтыг үндэслэн уг хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Уг эрхийг компани нь нэгэн адил эдэлнэ.

4.10. Компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч нь компанийн санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг өөрийн зардлаар хийлгэх эрхтэй.

4.11. Хувьцаа эзэмшигч нь компанийн өмнөөс үүрэг хүлээхгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааныхаа эрсдэлээ хүлээнэ. Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

Тав. Компанийн үнэт цаас, түүнийг гаргах, худалдаж авах

5.1. Компани нь өөрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас болгох хувьцаа худалдан авах эрхийн бичиг, хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион гаргаж болох бөгөөд уг шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу ТУЗ-өөс

гаргана. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт гаргах үнэт цаасны төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн, үүнээс үүсэх хөрөнгийг ашиглах зорилго үнэт цаасыг нийтэд эсхүл хаалттай захиалгаар худалдах, үнэт цаас нь энгийн хувьцаанд хөрвөх эсэх болон бусад нөхцөл зэргийг заасан байна.

5.2. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс баталсан журмын дагуу бүртгүүлэх, нийтэд зарлах, андөррайтер болон зуучлах үнэт цаасны компанитай гэрээ байгуулан ажиллах асуудлыг Гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.

5.3. Үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

5.4. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг ТУЗ-ийн шийдвэрийн дагуу дараах нөхцөлд худалдан авч болно. Үүнд:

5.4.1. Компани үнэт цаасаа худалдан авах буюу эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байх;

5.4.2. Компанийн өөрийн хөрөнгө нь гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс их байх.

Зургаа. Компанийн санхүүгийн тайлан, бүртгэл, ногдол ашиг

6.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусгавар болно.

6.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлбөл зохих татвар, хураамжийг тухай бүрд нь хугацаанд нь төлж байна.

6.3. Компани нь холбогдох хууль тогтоомж, олон улсын бүртгэл тооцооны стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайланг татвар санхүүгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлж, ээлжит ХЭХ-д танилцуулна.

6.4. Хэрэв компанийн санхүүгийн гүйлгээ нь мөнгөний өөр нэгжээр хийгдээгүй бол Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөг нь санхүүгийн бүртгэлийг хөтлөх мөнгөний нэгж байна.

6.5. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

6.5.1. Санхүүгийн байдлын тайлан;

6.5.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан;

6.5.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан;

6.5.4. Мөнгөн гүйлгээний тайлан;

6.5.5. Нэмэлт тодруулга;

6.5.6. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл;

- 6.6. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш тавин (50) өдрийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 6.7. Дараах нөхцлийг биелүүлсний дараа компанийн нийт цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:
- 6.7.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 6.7.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуульд заасан доод хэмжээнээс их байх;
 - 6.7.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй хувьцааг бүрэн авсан байх;
- 6.8. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд төлбөр төлснөөс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.
- 6.9. Ногдол ашиг хуваарилаагүй бол түүний шалтгааныг ТУЗ хувьцаа эзэмшигчдэд тайлбарлаж мэдэгдэнэ.
- 6.10.** Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас тусгай зориулалтын санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмыг Гүйцэтгэх захирал боловсруулна.

Долоо. Компанийн удирдлага

А. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ байна.
- 7.2. ХЭХ нь ээлжит болон ээлжит бус байна.
- 7.3. ХЭХ-ыг ТУЗ-ийн шийдвэрээр томилогдсон этгээд удирдан явуулна.
- 7.4. Ээлжит ХЭХ-ыг тухайн жилийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-өөс зарлан хуралдуулсан байна.
- 7.5. Энэ дүрмийн 7.4-т заасан хугацаанд ээлжит ХЭХ-ыг хуралдуулаагүй тохиолдолд Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн (эзгүй үед нь Гүйцэтгэх удирдлага) ээлжит бус ХЭХ-ийг хуралдуулахаас бусад эрх нь дуусгавар болно.
- 7.6. Ээлжит болон ээлжит бус ХЭХ-ыг зарлан хуралдуулахтай холбоотой аливаа зардлыг Компани хариуцна.
- 7.7. Ээлжит бус ХЭХ-ыг шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн шийдвэрээр, ТУЗ-ийн нэг ба түүнээс дээш хараат бус гишүүдийн шаардсанаар эсхүл саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн санаачилгаар Компанийн тухай хуульд заасны дагуу зарлан хуралдуулж болно.
- 7.8. ХЭХ-аар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 7.8.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

- 7.8.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
 - 7.8.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмэлт хувьцаа гаргах;
 - 7.8.4. Компанийг татан буулгах, татан буулгах комисс томилох;
 - 7.8.5. Хувьцааг хуваах, нэгтгэх;
 - 7.8.6. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, цалин урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 7.8.7. ТУЗ-өөс гаргасан санхүүгийн болон компанийн үйл ажиллагааны тайлан, мөн Аудитын хорооны тайланг хэлэлцэж батлах;
 - 7.8.8. Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувьтай тэнцэх хувьцааг худалдаж авах;
 - 7.8.9. Энэхүү дүрмийн 4.6-д заасан ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн зүгээс гаргасан бусад асуудал.
- 7.9. Энэ дүрмийн 7.10-д зааснаас бусад асуудлыг ХЭХ-д биөчлэн болон эчнээгээр оролцогчдын дийлэнх олонхийн буюу 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.
- 7.10. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо Компанийн тухай хуульд заасан санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. ТУЗ-ийн гишүүдийг хүлээн зөвшөөрсөн саналын тооны дарааллаар сонгоно.
- 7.11. ХЭХ-ыг ТУЗ-өөс гаргасан тогтоол, шийдвэрийг үндэслэн Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу зохион байгуулна.
- 7.12. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор ХЭХ хүчин төгөлдөр болно. Хэрэв ХЭХ хүчин төгөлдөр байх ирц бүрдээгүй бол хурлыг хойшлуулан дараагийн хурлыг ажлын (20) хоногт багтаан товлож хуралдуулах ба хойшлуулсан хурлын он, сар, өдөр, хурал болох газар болон цагийг ХЭХ болохоос долоо (7)-оос доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 7.13. Дор дурдсан асуудлаас бусад асуудлыг ХЭХ-аар хэлэлцэх тохиолдолд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно.
- 7.13.1. Холбогдох хууль, журмын дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдэх асуудлууд;
 - 7.13.2. Компанийн дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;
 - 7.13.3. Компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах.
- 7.14. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь өөрөө хүсвэл эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох эрхтэй.

7.15. ХЭХ-ын тэмдэглэлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлж, хурлын дарга баталгаажуулна.

Б. Төлөөлөн удирдах зөвлөл

7.16. Компанийн тухай хуульд зааснаар ХЭХ-ын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-аар гурав 3 хүртэл жилийн хугацаатай сонгоно.

7.17. ТУЗ нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэг (1/3) нь Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүд байна.

7.18. ТУЗ-ийн төрийн өмчийн төлөөлөгч болох өрдийн 6 гишүүнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, хараат бус 3 гишүүнийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос тус тус нэр дэвшүүлж, ХЭХ-аас сонгоно.

7.19. ТУЗ нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана. Үүнд:

7.19.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бизнесийн үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргах;

7.19.2. Ээлжит болон ээлжит бус ХЭХ-ыг зарлах, хэлэлцэх асуудлыг тогтоох, хуралтай холбоотой бусад асуудлууд;

7.19.3. Энэхүү дүрэмд туссан асуудлууд болон хувьцаа, үнэт цаас гаргах шийдвэр гаргах;

7.19.4. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Компанийн эд хөрөнгийн зах зээлийн ханш болон үнийг тодорхойлох, батлах;

7.19.5. Компанийн 5 хувь хүртэл энгийн хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдан авах;

7.19.6. Гүйцэтгэх захирлыг томилох, түүний эрх үүрэг болон цалин, урамшууллын талаар гэрээ байгуулах;

7.19.7. Компанид аудитын үйлчилгээ үзүүлэх хараат бус аудитын байгууллагыг сонгож түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох;

7.19.8. Компанийн жилийн бизнес төлөвлөгөөг батлах;

7.19.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;

7.19.10. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох;

7.19.11. ТУЗ болон Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмыг батлах;

7.19.12. Компанийн салбар төлөөлөгчийн газрыг байгуулах;

7.19.13. ТУЗ-ийн гишүүдийн өргөн барьсан бусад асуудлууд.

7.20. Энэ дүрмийн 7.19.4, 7.19.7-д заасан асуудлыг хэлэлцэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх хувийн санал шаардлагатай.

7.21. Дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөнө:

7.21.1. ТУЗ-ийн гишүүнээс татгалзах тухайгаа компанид албан бичгээр мэдэгдсэн;

7.21.2. Монгол Улсын Иргэний хуулийн дагуу гишүүнийг эрх зүйн чадамжгүй гэж зарласан;

7.21.3. ХЭХ-ын шийдвэрээр;

7.21.4. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон;

7.21.5. Хуульд заасан бусад үндэслэл

7.22. Чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэл түүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ-өөс түр томилж болно.

7.23. ТУЗ-ийн долоо (7)-оос доошгүй гишүүний дэмжсэн саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга даргалах бөгөөд түүнийг биеэр оролцоогүй тохиолдолд хурлыг ТУЗ-ийн даргын томилсон гишүүн даргалах ба уг гишүүн нь энэ дүрмийн 7.26-т заасан таслах эрх эдлэхгүй.

7.24. ТУЗ-ийн хурлыг тухайн санхүүгийн жилд 4-өөс доошгүй удаа зарлан хуралдуулах ба хурал хуралдуулах тухай мэдэгдлийг боловсруулан хурлыг товлосон өдрөөс 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлнэ. Ажлын шаардлагаар энэхүү хугацааг ТУЗ-ийн гишүүдийн зөвшөөрснөөр богиносгож болно.

7.25. ТУЗ-ийн хурлын хүчинтэй байх ирцийн тоог дийлэнх олонх буюу 6-аар тогтоох ба хурлаар хэлэлцэж буй асуудлыг оролцож буй гишүүдийн (2/3) буюу дийлэнх олонх болон түүнээс дээш тооны гишүүдийн баталсан саналаар шийдвэрлэнэ.

7.26. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудалд гишүүд тус бүр нэг санал өгнө. Санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн дарга таслах санал өгнө.

7.27. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцаж холбогдох бичиг баримтыг Компанийн тухай хуульд заасны дагуу хөтлөх, хадгалах бөгөөд хувьцаа эзэмшигчдийг хууль тогтоомжоор хориглосноос бусад бичиг баримттай танилцах боломжоор хангах үүрэгтэй.

7.28. ТУЗ нь дэргэдээ Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодтой байх ба тэдгээрийн гишүүдийн гуравны хоёр (2/3) нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

В. Гүйцэтгэх удирдлага

7.29. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон ТУЗ-тай байгуулсан гэрээ, Компанийн тухай хуулийн 83.1, 83.2, 83.3-р зүйлд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

7.29.1. Зах зээлийн үнэлгээгээр 300.000 ам.доллараас доош хэмжээтэй Компанийн хөрөнгийг /нэг буюу олон удаагийн үйлдлээр/ захиран зарцуулах тохиолдолд Гүйцэтгэх захирал бие дааж шийдвэр гаргаж үр дүнг ТУЗ-д танилцуулна.

7.30. Гүйцэтгэх захирал нь бусад компани, ашгийн төлөө хуулийн этгээдэд албан тушаал хашихыг хориглоно.

Найм. Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн хариуцлага

8.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч болон газрын дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

8.3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг холбогдох журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Компанийн аудит

А. Дотоод аудит

9.1. Компанийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг ТУЗ-ийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

9.2. ТУЗ-ийн Аудитын хороо нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, энэхүү дүрэм, ХЭХ-ийн шийдвэртэй нийцүүлэн хяналт тавина.

9.3. ТУЗ-ийн Аудитын хороо нь шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангуулахад чиглэсэн зөвлөмжийг Гүйцэтгэх захиралд өгч энэ талаар ТУЗ-д танилцуулна.

9.4. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын нэгж хэрэгжүүлнэ.

9.5. Дотоод хяналтын нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн зохион байгуулалт, санхүү, нягтлан бодох бүртгэл зэрэг бүхий л асуудалд Гүйцэтгэх захирлын баталсан холбогдох журмын дагуу хяналт тавьж, дүгнэлт гаргана.

Б. Хөндлөнгийн аудит

9.6. Компанийн санхүүгийн шалгалтыг мэргэшсэн нягтлан бодогч нараас бүрдсэн аудитын байгууллагаар гэрээний үндсэн дээр хийлгэнэ.

9.7. Аудитын байгууллага нь Аудитын тухай хуулийн дагуу компанийн санхүү эдийн засгийн тайлангуудтай холбогдсон бүх асуудлуудыг шалгана.

9.8. Ээлжит бус аудитын шалгалтыг энэ дүрмийн 4.10-т заасны дагуу болон ТУЗ, Гүйцэтгэх захирал, Аудитын хорооны хүсэлтээр хийлгэж болно.

9.9. Хувьцаа эзэмшигчдийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг компани хариуцаж төлнө. Хувьцаа эзэмшигчдийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад аливаа албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хувьцааны хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

9.10. Компанийн холбогдох албан тушаалтан нь аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

9.11. Аудитор нь Компанийн тухай хуульд заасны дагуу дүгнэлт гаргаж ХЭХ-д тайлбар өгөх үүрэгтэй.

Арав. Компанийг татан буулгах

10.1. Компанийг Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хуульд заасны дагуу ХЭХ болон шүүхийн шийдвэрээр татан буулгана.

10.2. Татан буулгах тухай шийдвэр гарсан тохиолдолд ХЭХ эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах комиссыг томилно.

10.3. Татан буулгах комисс томилогдсоноор Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ. Татан буулгах комисс нь дээр дурдсан хуулийн дагуу үүргээ гүйцэтгэнэ.

10.4. Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан байгууллага Компанийг улсын бүртгэлээс хассанаар компанийг татан буугдсанд тооцно.

Арван нэг. Дүрэм хүчин төгөлдөр болох

11.1. ХЭХ-аар баталж, хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагад бүртгүүлснээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах тухай

Монгол Улсын Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Ү-2201007056 тоот улсын бүртгэлийн дугаартай, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 30 дугаар байр, 47 тоот хаягт байрлах 28 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцыг Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Технологийн газрын Техникийн ашиглалт үйлчилгээний албаны ахлах инженер Д.Нарантуяад, Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгийн 3401496002 тоот бүртгэлтэй, Төв аймаг, Зуунмод сумын 1 дүгээр баг, 27 дугаар байр, 12 тоот хаягт байрлах 29 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцыг Төв аймгийн Холбооны газрын дарга Ц.Оюунчимэг нарт тус тус хувьчлан олгосугай.
2. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 30 дугаар байр, 47 тоот хаягт байрлах 28 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцны үлдэгдэл өртөг болох 11,256,538.27 төгрөгийг төлөхийг Д.Нарантуяад, Төв аймаг, Зуунмод сумын 1 дүгээр баг, 27 дугаар байр, 12 тоот хаягт байрлах 29 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцны үлдэгдэл өртөг болох 3,077,407.23 төгрөгийг төлөхийг Ц.Оюунчимэгт тус тус даалгасугай.
3. Орон сууц хувьчлах, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, компанийн үндсэн хөрөнгөөс хасах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Алтан-Очир)-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН